



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 149

Улаанбаатар хот

“Хөдөө аж ахуйн биржийн арилжааны
зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагааны зохицуулалтын журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журам нь 2014 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилнэ.
3. Журам батлагдсантай холбогдуулан үйл ажиллагааны дотоод журам, заавруудад зохих өөрчлөлтийг оруулж, мөрдөж ажиллахыг Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-дын гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.
4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000152

**ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖИЙН АРИЛЖААНЫ ЗУУЧЛАГЧ /БРОКЕР/-ИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/ /цаашид “ХААБ” гэх/-ийн Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 3.1.5 дахь заалтад заасан үйл ажиллагааг эрхлэхэд харилцагчийн захиалга хүлээн авах, захиалга биелүүлэх, цуцлах, дуусгавар болгох, төлбөр тооцоо гүйцэтгэх, бараа, түүхийн эдийн хадгалалт, тээвэрлэлт, зар сурталчилгаа, дотоод хяналтын үйл ажиллагаа, баримт бичиг хадгалалт, хяналт, шалгалт, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. ХААБ нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос бараа, түүхий эдийг гэрээний үндсэн дээр хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж /цаашид “бирж” гэх/-ээр зуучлан арилжихтай холбогдуулан гаргасан журам, заавар, зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдөнө.

1.3. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурьдсан утгаар ойлгоно:

- 1.3.1. “бараа, түүхий эд” гэж хуулийн 3.1.2-т заасныг;
- 1.3.2. “биржийн арилжаа” гэж хуулийн 3.1.6-д заасныг;
- 1.3.3. “дэнчин” гэж хуулийн 3.1.7-д заасан барьцаа мөнгөн хөрөнгийг;
- 1.3.4. “харилцагч” гэж ХААБ-тай захиалгын гэрээ байгуулсан этгээдийг;
- 1.3.5. “захиалгын гэрээ” гэж ХААБ болон харилцагчийн хооронд байгуулах худалдах, худалдан авах үнэ, хэмжээг тодорхойлсон, биржээр зуучлан арилжих үйлчилгээ үзүүлэх гэрээг;
- 1.3.6. “худалдах, худалдан авах гэрээ” гэж бирж дээр биелсэн хэлцлийн дагуу харилцагчид хоорондоо байгуулах, бараа, түүхий эдийг худалдах, худалдан авах үйл ажиллагааг тодорхойлсон гэрээг;
- 1.3.7. “төлбөр хийсэн өдөр” гэж бараа, түүхий эдийг худалдан авсан талын гэрээний үнийн дүн төлбөр тооцооны төвийн дансанд шилжин орсон өдрийг;
- 1.3.8. “төлбөр тооцооны төв” гэж хуулийн 6.1-д заасны дагуу гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргийг гүйцэтгэгчийг;

1.3.9. “ХААБ-ийн үйлчилгээний шимтгэл” гэж биелсэн хэлцлийн үнийн дүнгээс худалдах, худалдан авах захиалга өгсөн харилцагч тус бүрээс зуучлалын үйлчилгээ үзүүлсэн хөлсийг захиалгын үнийн дүнгээс хувь ногдуулан тооцсон мөнгөн дүнг;

1.3.10. “зар сурталчилгаа” гэж бараа, түүхий эдийг худалдах, худалдан авахад зуучлах үйлчилгээг санал болгож, боломжит харилцагчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн мэдээллийг;

1.3.11. “гэрээний төрөл” гэж хуулийн 7.1-д заасан гэрээнүүдийг;

1.3.12. “хэлцэл” гэж биржийн арилжаанд оролцогчдын хооронд бараа, түүхий эдийг худалдах, худалдан авах тохиролцоог;

1.3.13. “холбогдох этгээд” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.30.-д заасан этгээдийг;

1.3.14. “нэгдмэл сонирхолтой этгээд” гэж Компанийн тухай хуулийн 99.1-д заасан этгээдийг;

Хоёр. Үйл ажиллагааны зарчим

2.1. ХААБ нь харилцагчийн эрх ашгийг хамгаалах, бараа, түүхий эдийн зах зээлийн шударга өрсөлдөөнийг хангах үүднээс дараах зарчмыг баримталж ажиллана:

2.1.1. холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;

2.1.2. үйл ажиллагаагаа ил тод, шударгаар явуулах;

2.1.3. харилцагчийн мэдээллийг баримтаар баталгаажуулан, зуучлалын үйлчилгээ үзүүлэхдээ захиалгын гэрээ заавал байгуулсан байх;

2.1.4. арилжаанд шударгаар оролцох, арилжааны талаарх мэдээ мэдээллийг үнэн зөв гаргах;

2.1.5. харилцагчийн захиалгыг цаг хугацааны дарааллын дагуу үнэн, зөв биржийн арилжаанд оруулах;

2.1.6. харилцагчийг бараа, түүхий эд худалдах, худалдан авах шийдвэр гаргахад шаардлагатай үнэн зөв мэдээллээр хангах;

2.1.7. өөрийн үйл ажиллагааны санхүүгийн үр дүн, ашиг алдагдал, зээлийн үлдэгдэл болон бусад шаардлагатай мэдээллийн талаар харилцагчид үнэн зөв мэдээлэл өгөх;

2.1.8. хууль, журамд заасан төлбөл зохих шимтгэл хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсийг цаг тухайд нь бүрэн төлөх;

2.1.9. бараа, түүхий эдийн зах зээл дээр үнийн бус өрсөлдөөнийг дэмжиж ажиллах;

2.1.10. хуулийн 3.1.2-т заасан шаардлагыг хангасан бараа, түүхий эдийг арилжаалах.

2.2. ХААБ өөрийн үйл ажиллагаанд мөрдөхөөр баталсан дүрэм, журмуудыг хэрэгжүүлж ажиллах ба компанийн сайн засаглалыг төлөвшүүлнэ.

2.3. ХААБ биелсэн захиалгын гэрээ тус бүрээс үйлчилгээний шимтгэл авна. Шимтгэл авах, тооцох аргачлал, хувь хэмжээг ХААБ дотоод журмаар тогтоож мөрдөнө.

2.4. ХААБ өөрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг харилцагчийн хүсэлтээр өгөх үүрэгтэй.

Гурав: Хориглох үйл ажиллагаа

3.1. ХААБ нь хуулийн 12 дугаар зүйлд заасан болон дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

3.1.1. олон нийт болон харилцагчдад хүргэх мэдээллийг нуун дарагдуулах;

3.1.2. бараа, түүхий эдийн үнийг тодорхой түвшинд зохиомлоор тогтоон барих, өсгөх, бууруулах үйлдэл хийх;

3.1.3. ХААБ болон нэгдмэл сонирхолтой бусад этгээдийн хооронд давхар гүйлгээ хийх;

3.1.4. ХААБ, Биржийн ажилтнууд дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох, арилжаанд оролцох боломж олгох;

3.1.5. өрсөлдөөнийг хязгаарлах зорилгоор бараа, түүхий эдийн үнэ, арилжаалах нөхцөл, шимтгэл болон бусад асуудлаар бусад ХААБ-тай тохиролцох, эсвэл өөрчлүүлэх зорилгоор шууд болон шууд бус замаар нөлөөлөх;

3.1.6. харилцагчийн хөрөнгөөр баталгаа, батлан даалт гаргах, эд хөрөнгийг барьцаалуулах;

3.1.7. харилцагчийн нууцлахыг хүссэн мэдээллийг эрх бүхий байгууллагаас бусад этгээд, олон нийтэд зөвшөөрөлгүй тараах;

3.1.8. бирж, даатгал, тусламжийн сангийн ажилтан, хууль тогтоомжоор аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон этгээдтэй захиалгын гэрээ байгуулах;

3.1.9. худалдан авах захиалга өгсөн харилцагчийн дэнчинг өөрийн хөрөнгөөс төлбөр тооцооны төвд байршуулах.

Дөрөв. Харилцагчийн захиалга хүлээн авах

4.1. Харилцагчтай захиалгын гэрээ байгуулахын өмнө ХААБ нь бараа, түүхий эдийн зах зээлийн талаарх ерөнхий ойлголт өгөх зорилгоор дараах мэдээллийг заавал танилцуулж гарын үсэг зуруулсан байна:

4.1.1. хэлцэл хийгдэх буюу арилжаа явагдах үйл явц, механизм;

4.1.2. хуулийн 7.1-д заасан гэрээгээр бараа, түүхий эдийг худалдах, худалдан авахад хүлээж болох эрсдэл.

4.2. ХААБ нь харилцагчтай захиалгын гэрээ байгуулахдаа харилцагчаас дараах баримт бичгийг шалган бүрдүүлнэ:

4.2.1. Харилцагч хувь хүн бол иргэний үнэмлэх, хэрэв гадаадын иргэн бол гадаад паспортгүйн хуулбар, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

4.2.2. Бичгээр гаргасан захиалгын хүсэлт;

4.2.3. Худалдан авах зорилго бүхий захиалгын гэрээ байгуулах бол харилцагчийн нэр дээрх дансанд буй мөнгөн хөрөнгө нь хүрэлцээтэй эсэхийг нотолсон баримт, баталгаа, дансны хуулга,

4.2.4. Худалдах зорилго бүхий захиалгын гэрээ байгуулах бол агуулахад бараа хүлээлцсэн тухай баримт, бараа, түүхий эдийн гарал үүслийн тодорхойлолт, чанарын гэрчилгээг нотолсон баримт бичиг.

4.3. Талууд дараах нөхцөлүүдийг заавал тохирсон байна:

4.3.1. худалдах, худалдан авах бараа, түүхий эдийн нэр;

4.3.2. бараа, түүхий эдийн тоо хэмжээ ;

4.3.3. бараа, түүхий эдийн нэгжийн үнэ;

4.3.4. төлбөр тооцоо гүйцэтгэх нөхцөл;

4.3.5. гэрээний төрөл;

4.3.6. эрсдэлийг хэрхэн хуваарилах.

4.4. Захиалгын гэрээнд харилцагчийн нэр, регистрийн дугаар /гадаадын иргэн бол гадаад паспортын дугаар/, гарын үсэг, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, төлөөлөх эрх бүхий этгээдийн нэр, албан тушаал, хуулийн этгээдийн тэмдэг, ХААБ-ийн захиалга хүлээн авсан брокерийн нэр, гарын үсэг, гэрээний хүчин төгөлдөр хугацаа, гэрээ байгуулсан огноо, цаг минут заавал байна. Эдгээрийн аль нэг нь байхгүй тохиолдолд гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэл болно.

4.5. Харилцагчтай захиалгын гэрээ байгуулснаар ХААБ түүний нэрийн өмнөөс арилжаанд оролцож, гэрээний дагуу эрх, үүргийн биелэлтийг бүрэн хариуцна.

4.6. ХААБ нь холбогдох хууль, журам зөрчих нөхцөлтэй харилцагчийн захиалгыг хүлээн авахгүй.

Тав. Захиалгын гэрээг биелүүлэх, цуцлах, дуусгавар болгох

5.1. Захиалгын бүртгэлийг бичгээр болон цахим хэлбэрээр дугаарыг давхардуулахгүй хөтлөнө. Захиалгыг үнийн болон цаг хугацааны дарааллаар нэгтгэн арилжаа эхлэхээс өмнө бэлэн болгоно.

5.2. Захиалгын бүртгэл хийгдсэний дараа харилцагч захиалгын гэрээнд өөрчлөлт оруулсан бол захиалгыг хүлээн авсан брокер зохих өөрчлөлтийг оруулна.

5.3. Ижил нөхцөлтэй захиалгыг бараа, түүхий эд худалдан авахад үнийн доод, худалдахад үнийн дээд хэмжээг үндэслэн, үнэ тэнцсэн тохиолдолд хугацааны дарааллаар тус тус биелүүлнэ.

5.4. Харилцагч өөрийн захиалгын гэрээний нөхцлүүдэд арилжааны явцад өөрчлөлт оруулах, цуцлах эрхтэй.

5.5. Захиалгын гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулахад түүний хүчин төгөлдөр байх хугацаа өөрчлөгдөхгүй.

5.6. Харилцагч захиалгын гэрээг цуцлахыг хүсвэл энэ тухай ХААБ-д мэдэгдэж захиалгын бүртгэлд тэмдэглэл хийлгэнэ.

5.7. Захиалга нь дараах тохиолдолд дуусгавар болно:

5.7.1. захиалгыг бүрэн биелүүлсэн;

5.7.2. бараа, түүхий эд худалдан авахаар захиалгын гэрээнд заасан мөнгөний хэмжээнд хүрсэн, дансанд байршуулсан мөнгө дууссан;

5.7.3. захиалгын гэрээний үйлчлэх хугацаа дууссан;

5.8. ХААБ нь захиалгын гэрээг биелэгдэхэд бараа, түүхий эдийн нэр, код, хэлцэл хийгдсэн өдөр, үнэ, хэмжээ, шимтгэлийн хэмжээний талаарх мэдээллийг харилцагчид цахим шуудан, утас, факс, бусад боломжит харилцаа холбооны хэрэгслээр нэн даруй мэдэгдэнэ.

Зургаа. Арилжааны төлбөр тооцоо

6.1. ХААБ-ийн арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэхтэй холбоотой доор дурдсанаас бусад үйл ажиллагааг төлбөр тооцооны төвийн журмаар зохицуулна:

6.1.1. ХААБ нь төлбөр тооцооны төвд өөрийн харилцагчийн нэр дээр данс нээх бөгөөд мөнгөн хөрөнгийн хэмжээ биржээс тогтоосон шаардлагыг хангаж байгаа тохиолдолд тухайн өдрийн арилжаанд оролцох;

6.1.2. Арилжааны өдөр бүрийн эцэст ХААБ нь харилцагч тус бүрийн дансны төлбөр тооцооны тайланг харилцагчид мэдээлэх;

6.1.3. ХААБ нь аливаа төлбөр тооцоо хийгдсэн талаарх баримт материалыг бүртгэж, хадгалах;

Долоо. Агуулах ба бараа, түүхий эд хүргэлт

7.1. ХААБ нь биржээр арилжаалах бараа, түүхий эдийг худалдах захиалга хүлээн авахтай холбогдуулан дараах үйл ажиллагааг явуулна:

7.1.1. бараа, түүхий эдийн чанар, гарал үүслийн баталгааны хуудсыг шалган баталгаажуулсаны дараа бараа, түүхий эдийг агуулахад хүлээн авч, агуулахын хүлээн авсан баримтын нэг хувийг хадгална;

7.1.2. хэлцэл биелсэн захиалгын гэрээний бараа, түүхий эдийг агуулахаас тээвэрлэлтэд өгч, гэрээнд заасан эсвэл худалдан авагчийн тодорхойлсон цэгт хүргэж өгнө;

7.1.3. биржээс тогтоосон хугацаанд ХААБ худалдагч талын бараа, түүхий эдийн чанар, гарал үүслийн баталгааны хуудас болон татвар төлсөн баримтыг Төлбөр тооцооны төвд өгөх, төв худалдан авагчийн төлбөрийг худалдагч талд шилжүүлэн, худалдан авагчид бараа, түүхий эдийн чанар, гарал үүслийн баталгааг хүлээлгэн өгснөөр бараа, түүхий эдийг хүргэх үйл ажиллагаа эхэлнэ;

7.1.4. бараа, түүхий эд худалдан авагч тал нь биржээс тогтоосон тодорхой хугацааны дотор бараа хүргэлтийн үйл ажиллагаа хангалтгүй байгаатай холбогдуулан хяналт хийлгэх биржид хүсэлт гаргаж болно;

7.1.5. бараа, түүхий эдийг эхэлж ирснийг эхэлж зарлагдах аргаар хүргэлт хийнэ;

7.1.6. хэлцэл биелсэн бараа, түүхий эдийн төлбөр тооцоо хийгдсэнээр барааг хүргэж өгөхөөр тээвэрт ачуулах бөгөөд, агуулахаас бараа, түүхий эд ачуулсан баримтыг өөртөө заавал хадгална;

7.1.7. агуулах, хүргэлтийн үйл ажиллагаатай бусад харилцааг биржийн баталсан журмаар зохицуулна.

Найм. Зар сурталчилгаа

8.1. ХААБ нь Биржээр арилжаалахыг зөвшөөрсөн бараа, түүхий эдийг худалдах болон худалдан авахад зуучлахтай холбоотой зар сурталчилгааг нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон утас, цахим хуудас, цахим шуудан, хэвлэмэл хуудас зэрэг бусад хэлбэрээр явуулж болно.

8.2. Зар сурталчилгаа нь бодит байдалд нийцсэн байх бөгөөд төөрөгдүүлсэн, үндэслэлгүй мэдээлэл агуулаагүй байна.

8.3. ХААБ нь бараа, түүхий эдийн арилжааны талаар нийтэд мэдээлэл хүргэхдээ буруу ойлголт төрүүлэхгүй, төөрөгдүүлэхгүй байх үүднээс мэдээлэл хүрэх этгээдүүдийн ерөнхий мэдлэг, ойлголтыг харгалзана.

8.4. ХААБ-уудын гишүүнчлэл бүхий мэргэжлийн холбооноос тогтоосон ХААБ-аас нийтэд мэдээлэл хүргэх, зар сурталчилгаа явуулах стандартыг мөрдөх үүрэгтэй.

8.5. ХААБ нь гуравдагч этгээдээс авсан аливаа мэдээллийг бараа, түүхий эд худалдах, худалдан авахыг санал болгох, нийгэд мэдээлэл хүргэх үйл ажиллагаа, зар сурталчилгаа явуулахдаа ашиглах бол түүнийг үндэслэлтэй эсэхийг шалгасны үндсэн дээр иш татаж ашиглана.

8.6. Үндэслэлтэй эсэхийг шалгалгүйгээр иш татан ашигласан мэдээлэл нь бодит байдалд нийцээгүй байсны улмаас аливаа этгээдэд учирсан хохирлыг ХААБ хариуцна.

Ес. Дотоод хяналт

9.1. Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, дотоод хяналтын ажилтан болон бусад ажилтны үүрэг, хариуцлагыг зааглан тодорхой болгож дотоод хяналтын үйл ажиллагааг зохицуулах журамд тусгасан байна.

9.2. ХААБ-ийн нягтлан бодох бүртгэл, эрсдлийн удирдлагын хяналтыг бүрэн хамарч чадахуйц, үйл ажиллагааны үе шат бүрт хяналт тавьж болохуйцаар дотоод хяналтын бүтэц зохион байгуулагдсан байна.

9.3. Дотоод хяналтыг дотоод хяналтын ажилтан тогтмол болон гэнэтийн хяналт шалгалтаар хэрэгжүүлэх явцад ХААБ-ийн албан тушаалтан холбогдох хууль, журам зөрчсөн нь тогтоогдвол зөрчлийн талаар ТУЗ /хэрэв ТУЗ-гүй бол Хувьцаа эзэмшигчдийн хурал/-д нэн даруй мэдэгдэж зөрчлийг арилгуулна.

9.4. Дотоод хяналт шалгалтын тайлан, дүгнэлтийг улирал бүр Хороонд ирүүлнэ.

9.5. Дотоод хяналтын ажилтан нь үр нөлөө бүхий, шударга хяналтыг хэрэгжүүлж чадахуйц мэдлэг, дадал, туршлагатай байх ба ХААБ нь хяналтаа хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л нөхцөл бололцоогоор хангана.

Арав. Баримт бичиг хадгалах

10.1. ХААБ нь Компанийн тухай хуулийн 97.1 дэх хэсэгт заасан болон дараах баримт бичгийг хадгалах үүрэгтэй:

10.1.1. ХААБ-ийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичиг:

10.1.1.1. энэ журмын 4.2-т заасан баримтууд;

10.1.1.2. захиалгын гэрээ, худалдах, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой баримт бичиг;

10.1.1.3. харилцагчийн дансны мөнгөн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой баримтууд;

10.1.1.4. олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн зар сурталчилгааны талаарх мэдээлэл.

10.1.2. Бараа, түүхий эдийг хадгалалт, тээвэрлэлт хийхтэй холбогдсон баримт бичиг:

10.1.2.1. хэлцэл биелсэн бараа, түүхий эдийн чанар, гарал үүслийн баталгааны баримт бичиг;

10.1.2.2. бараа, түүхий эдийг агуулахад хүлээн авсан, хүлээлгэн өгсөн баримт;

10.1.2.3. хэлцэл биелсэн бараа, түүхий эдийг тээвэрлэн хүргэж өгсөн баримт;

10.1.2.4. сар бүрийн бараа, түүхий эдийн үлдэгдэл тооллогын баримт;

10.1.2.5. бараа, түүхий эдийг буцаан болон татан авсан, тэдгээртэй холбогдсон арга хэмжээний талаарх мэдээлэл, баримт бичиг.

10.1.3. Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичиг:

10.1.3.1. нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, журмын дагуу гаргасан тайлан, тэнцэл, тайлангийн нэмэлт тодруулга;

10.1.3.2. холбогдох болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийсэн хэлцлүүд.

10.1.4. Дотоод хяналтын үйл ажиллагаатай холбоотой баримт бичиг:

10.1.4.1. дотоод хяналтын үйл ажиллагааны улирал бүрийн тайлан, дүгнэлт;

10.1.4.2. дотоод хяналтын тайлангийн үр дүнд хийгдсэн ажлуудын биелэлт, тайлан, холбогдох баримт бичгүүд.

10.1.5. харилцагчийн гаргасан гомдол, түүний агуулга, шийдвэрлэсэн байдлын тайлан.

10.2. Компанийн тухай хуулийн 97.4-т заасан хугацаа өнгөрсөн болон компани татан буугдсаны дараа баримт бичгийг архивт шилжүүлэх харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

Арван нэг. Зайнаас тавих хяналт

11.1. ХААБ-ийн үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд Хорооноос тавих хяналтыг зайны болон газар дээрх хяналт, шалгалтын хэлбэрээр хэрэгжүүлнэ.

11.2. ХААБ нь тухай бүр энэ журмын Хавсралтын дагуу холбогдох мэдээллийг нэгтгэн, тайланг Хороонд цаасан болон цахим хэлбэрээр ирүүлнэ.

11.3. Энэ журмын хавсралтын дагуу мэдээ, тайланг хугацаанд нь бүрэн, үнэн зөв, зохих маягтын дагуу Хороонд ирүүлээгүй тохиолдолд холбогдох журмын дагуу хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

11.4. ХААБ-ийн эрх бүхий албан тушаалтнууд нь Хороонд ирүүлэх мэдээллүүдийг үнэн зөв гаргасан болохыг баталгаажуулан гарын үсэг зурж, тамга дарсан байна.

11.5. Хороо бүрэн гүйцэт мэдээллийг хүлээж авсан өдрөөр мэдээлэл ирүүлсэн өдрийг тооцно.

11.6. Хороо ирүүлсэн мэдээлэлд үндэслэн дараах байдлаар зайнаас тавих хяналтыг хэрэгжүүлнэ.

11.6.1. мэдээллийг үнэн зөв, тогтоосон хугацаанд гаргасан эсэх;

11.6.2. тухайн мэдээллийг өмнө нь өгч байсан бол түүнтэй нийцэж буй эсэх;

11.6.3. мэдээллийг маягтын дагуу бүрэн ирүүлсэн эсэх;

11.6.4. тайлбар үндэслэлтэй эсэх.

11.7. ХААБ-уудын зайнаас тавих хяналтын тайлангийн нэгтгэл, дүгнэлтийг улирал бүр гаргаж Хорооны удирдлагад танилцуулна.

Арван хоёр. Газар дээрх хяналт, шалгалт

12.1. ХААБ-ийн үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилт хангагдаж байгаа эсэхэд газар дээрх хяналт, шалгалтыг Хорооноос хэрэгжүүлнэ.

12.2. Газар дээрх хяналт, шалгалтыг ХААБ-ийн үйл ажиллагаа, биржээс итгэмжлэл олгосон агуулах, тээвэрлэгч, лаборатори зэрэг бусад объектод хийнэ.

12.3. Газар дээрх хяналт, шалгалт нь зорилгоос хамаарч иж бүрэн болон хэсэгчилсэн, хугацаанаас хамаарч ээлжит болон ээлжит бус гэсэн байдлаар хийгдэнэ.

12.4. Шаардлагатай гэж үзвэл Хорооноос хийх газар дээрх шалгалтыг Биржийн зохицуулах зөвлөл болон бусад холбогдох байгууллагатай хамтарсан хэлбэрээр гүйцэтгэж болно.

Арван гурав. Хариуцлага

13.1. Энэ журмыг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хуулийн 16 дугаар зүйл болон Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан хариуцлага ногдуулна.

---oOo---

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 5 дугаар сарын 7-ний өдрийн /160/ дүгээр тогтоолоор батлагдсан "Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагааны зохируулалтын журам"-ын хавсралт.




ХОРООНД ИРҮҮЛЭХ МЭДЭЭЛЭЛ, ТАЙЛАН

УХА0410 5043239

д/д	Хороонд ирүүлэх мэдээллийн жагсаалт	Маягт	Ирүүлэх хэлбэр	Мэдээлэл ирүүлэх давтамж	Мэдээлэх хэлбэр	Ирүүлэх хугацаа
1	ХААБ-ийн үйл ажиллагаа явуулж буй компанийн танилцуулга	Журмын хавсралтын Маягт 1	Цахим, цаасаар	Улирал бүр	Өөрчлөлтийг тусгасан байна.	Дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор
2	Арилжааны тайлан	Журмын хавсралтын Маягт 2	Цахим	Долоо хоног бүр	Өссөн дүнгээр	Дараа долоо хоногийн мягмар гарагт
3	Хорооны зохицуулалтын үйлчилгээний хөлсийн тайлан	Журмын хавсралтын Маягт 3	Цахим	Долоо хоног бүр	Өссөн дүнгээр	Дараа долоо хоногийн мягмар гарагт
4	Биелээгүй захиалгын мэдээлэл	Журмын хавсралтын Маягт 4	Цахим	Долоо хоног бүр	Өссөн дүнгээр	Дараа долоо хоногийн мягмар гарагт
5	Хүний нөөцийн мэдээлэл	Журмын хавсралтын Маягт 5	Цахим, цаасаар	Улирал бүр	Өөрчлөлтийг тусгасан байна.	Дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор
6	Нэгдмэл сонирхолтой этгээдийн тухай мэдээлэл	Журмын хавсралтын Маягт 6	Цахим, цаасаар	Улирал бүр	Өөрчлөлтийг тусгасан байна.	Дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор
7	Улирлын санхүүгийн тайлан	СЯ-ны А маягт Б маягт	Цахим, цаасаар	Улирал бүр	Өссөн дүнгээр	Дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор
8	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан, тодруулгын хамт	ТЕГ-ын Маягт 1 Маягт ТТ-02г	Цахим, цаасаар	Улирал бүр	Өссөн дүнгээр	Дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор
9	Дотоод хяналтын шалгалтын тайлан	Тайлан хэлбэрээр	Цахим, цаасаар	Улирал бүр	Өссөн дүнгээр	Дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 5 дугаар сарын 7-ний өдрийн 4 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуулагч /брокер/-ийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын хавсралтын Маягт 1.



..... ХААБ-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
/20... оны ... улирал/

№	Танилцуулга	Үзүүлэлт
1	ХААБ-ийн нэр	
2	Оршин байх газар, хаяг	
3	Холбоо барих утас	
4	И-мэйл хаяг	
5	Салбартай эсэх	Оршин байх газар, хаяг
		Утас, и-мэйл
7	Хувьцаа эзэмшигчдийн нэрс, эзэмшиж буй хувьцааны тоо, хувь, нэрлэсэн үнэ	
8	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ/төг/	
9	Гүйцэтгэх захирал	Овог, нэр
		Мэргэжил
		Утас, и-мэйл
10	Брокерийн овог нэр, мэргэжил, эрх авсан огноо	
11	Аж ахуй нэгжийн улсын гэрчилгээ	Регистр
		Дугаар
12	Гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээний дугаар	
13	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	Тогтоол
		Гэрчилгээ
6	Эрхэлж буй үйл ажиллагаа	Арилжих бараа, түүхий эд
		Арилжих гэрээний төрөл
14	ХААБ-ийн үйл ажиллагаа явуулж буй хугацаа	
15	Биржийн гишүүнчлэлийн эрх	Огноо
		Дугаар
16	Ямар холбооны гишүүн болох	
17	Сүүлийн 3 жилд арилжааны хэлцэл буцаагдаж байсан эсэх /тийм бол шалтгааныг тайлбарлах/	
18	Сүүлийн 3 жилд Хороо, биржээс компани болон ажилтанд хариуцлага хүлээлгэж байсан эсэх /тийм бол ямар зөрчил, шийтгэл, хүлээлгэсэн огноо/	

Боловсруулсан:/

Хянасан:/

(Тамга)

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 5 дугаар сарын 7-ний өдрийн дүгээр тогтоолоор батлагдсан "Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын хавсралтын Маягт 2.


..... **ХААБ-ИЙН АРИЛЖААНЫ ТАЙЛАН**

/20... оны ... сарын ... өдөр/

д/д	Худалдах захиалгын мэдээлэл								Худалдан авах захиалгын мэдээлэл							Арилжааны мэдээлэл					
	Харилцагчийн нэр	Регистрийн дугаар	Харилцагчийн данс	Захиалгын дугаар	Захиалгын төрөл	Брокерийн нэр	Агуулахын код	Харилцагчийн нэр	Регистрийн дугаар	Харилцагчийн данс	Захиалгын дугаар	Захиалгын төрөл	Брокерийн нэр	Агуулахын код	Хэлцлийн дугаар	Огноо	Бараньн код	Бараньн нэр	Ботпын хэмжээ	Ботпын үнэ	Үнийн дүн
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21
1																					
2																					
3																					
4																					
5																					
...																					

Боловруулсан: /
Хянасан: /
(Тамга)

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 5 дугаар сарын 7-ний өдрийн 40 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын хавсралтын Маягт 3.




... ХААБ-ИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСИЙН ТАЙЛАН
/20... оны ... сарын ... өдөр/

д/д	Харилцагчийн нэр	Огноо	Хэлцлийн дугаар	Арилжааны нийт дүн	Хорооны зохицуулалтын үйлчилгээний хөлс	Төлсөн огноо	Шилжүүлсэн данс	Тайлбар
0	1	2	3	4	5	6	7	8
1								
2								
3								
4								
5								
...								

Боловсруулсан:/ /
Хянасан:/ /
(Тамга)

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 5 дугаар сарын 7-ний өдрийн дүгээр тогтоолоор батлагдсан "Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын хавсралтын Маягт 4.



... ХААБ-ИЙН БИЕЛЭЭГҮЙ ЗАХИАЛГЫН МЭДЭЭЛЭЛ

/20... оны ... сарын ... өдөр/


УХА0410 5043239

д/д	Харилцагчийн нэр	Регистрийн дугаар	Агуулахын код	Захиалгын:			Барааны:		Богцын:		Нийт мөнгөн дүн
				Огноо	Дугаар	Төрөл	Код	Нэр	Хэмжээ	Үнэ	
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1											
2											
3											
4											
5											
...											

Боловсруулсан:

Хянасан:

(Тамга)



... ХААБ-ИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭДЭЭЛЭЛ


/20... оны ... улирал/

№	Овог, нэр	Эрхлэх албан тушаал	Регистрийн дугаар	Мэргэжил	Төгссөн сургууль, дипломын дугаар	ХААБ-ийн сургалтын гэрчилгээний дугаар	Холбоо барих утас	И-мэйл
0	1	2	3	4	5	6	7	8
1								
2								
3								
4								
5								
6								
7								
8								
9								
10								
...								

Боловруулсан:

Хянасан:
(Тамга)

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 5 дугаар сарын 7-ний өдрийн /2014/ дүгээр тогтоолоор батлагдсан "Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын хавсралтын Маягт 6.



**... ХААБ-ИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, АЖИЛТНУУДЫН НЭГДМЭЛ
СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ**

/20... оны ... улирал/

№	Эрх бүхий албан тушаалтан, ажилтны овог, нэр	Холбогдох этгээдийн овог, нэр	Хамаарал	Регистрийн дугаар
0	1	2	3	4
1				
2				
3				
4				
5				
6				
7				
8				
...				

Боловсруулсан:

Хянасан:

(Тамга)